



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 464

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2017 он, 2018 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар тус компани нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг зөрчин 326.6 сая төгрөгийн зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу эрх бүхий байгууллагаас дагаж мөрдөхөөр тогтоож өгсөн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллаагүйгээс зардлыг 2017 онд 2,478.4 сая төгрөгөөр, 2018 онд 317.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11, 8 дугаар зүйлийн 8.4, 12 дугаар зүйлийн 12.1, 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.4, 28 дугаар зүйлийн 28.7.3, 12 дугаар зүйлийн 12.1, 48 дугаар зүйлийн 1, Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолын холбогдох заалтыг зөрчин 3,214.9 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж явуулсан, Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх” журмыг мөрдөн ажиллаагүй, төрийн өөрийн өмчийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр түрээсийн журмаар ашиглуулан, түрээсийн орлогын 30 хувь 55.1 сая төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлээгүй зэрэг нийт 6,561.2 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ч.Чинбатад дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

2.2. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэлийг сайжруулах, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал, ажил үйлчилгээг санхүүжүүлэх, зөвшөөрөлгүй хөрөнгө худалдан авахыг таслан зогсоох;

2.3. 2017-2018 онд төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээсэлснээс олсон 176.5 сая төгрөгийн орлогод ногдох, 51.7 сая төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллах;

0000981

2.4. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар тогтоолын 2.2-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байх”, 2.5-д “компанийн удирдлага, ажиллагсдын цалин хөлс, урамшууллын тогтолцоог компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагаа, төрд төлсөн ногдол ашигт тулгуурлан тооцох аргачлал, гаргаж мөрдүүлэх” гэж заасныг мөрдөн ажиллах;

2.5. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.6. Худалдан авах ажиллагааг нэгж, хэлтсээс мэргэжлийн төлөөлөл оролцуулах замаар байгууллагын хэмжээнд нэгдсэн удирдлага дор зохион байгуулах, үнэлгээний хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг хууль журамд нийцүүлэх, давхардлыг бууруулах арга хэмжээ авах;

2.7. Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан “КОНТРАКТ”-ын 3.5 дахь хэсэгт заасан хүний нөөцийн бодлого боловсруулж, батлах заалтыг хэрэгжүүлэх, хүний нөөцийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөх;

2.8. Компанийн эзэмшилд байгаа, орон сууцны зориулалт бүхий 14170 м2 газар эзэмших, ашиглах эрхийг нийтийн эзэмшилд, Нийслэлийн боловсролын газарт хүлээлгэн өгсөн “Эрчим” цэцэрлэгийн газрыг тухайн байгууллагын нэр дээр шилжүүлэх асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд судлан шийдвэрлүүлэх;

2.9. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-д ажил гүйцэтгэхээр гадны компанийн оруулж ирж буй сэлбэг материалыг бүртгэх, хяналт тавих журам”, “Хуучин сэлбэг материал хүлээн авах, худалдах, дахин ашиглах журам”-уудын хэрэгжилтийг ханган ажиллах, байгууллагын Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажлын үр нөлөөг дээшлүүлэх;

2.10. Шалгалтын тайланд дурдсан зөрчил дутагдлыг арилгах, зөрчил дутагдал гаргасан, хяналт тавих чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн, үргүй зардал гаргасан ажилтан, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хариуцлага тооцож, 2019 оны 4 дүгээр улиралд багтаан биелэлтийг ирүүлэх;

2.11. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн
464 дугаар тогтоолын хавсралт

**“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-д хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт**

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Хамрах хугацаа	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Батлагдсан зардлыг хэтрүүлсэн	2017-2018 он	2,795.70	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт, гүйцэтгэх захиралтай байгуулсан Контрактын 1.4, 3.2 дахь хэсэг	Эрх бүхий байгууллагаас баталсан төлөвлөгөөг мөрдөн ажиллах, хууль, журмын хэрэгжилтийг ханган ажиллах.
2	Дээд байгууллагын зардлыг санхүүжүүлсэн, зарим үргүй зардал гаргасан	2017-2018 он	47.5	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар тогтоолын 2.2 дахь хэсэг	Дээд байгууллагын зардал, үргүй зардал гаргахгүй байх, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах
3	2017, 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагаагүй зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн	2017-2018 он	326.56	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг	Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэлийг сайжруулах
4	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулаагүй, төсөвт гондох орлогыг төвлөрүүлээгүй	2017-2018 он	176.5	Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр, гэрээний дагуу ашиглуулах, хууль журмыг мөрдөн ажиллах
5	Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, холбогдох журмыг зөрчин зохион байгуулсан	2017-2018 он	3,214.91	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11, 8 дугаар зүйлийн 8.4, 12 дугаар зүйлийн 12.1, 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.4, 28 дугаар зүйлийн 28.7.3, 12 дугаар зүйлийн 12.1, 48 дугаар зүйлийн 1, 21 дүгээр зүйлийн 1, 19, 8 дугаар зүйл, Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолын холбогдох заалт	Худалдан авах ажиллагааг хууль, журмын хүрээнд зохион байгуулах
НИЙТ ДҮН:			6,561.17		